| 210803        | Даатгалын үйлчилгээ   | 377,500.00              | 168,600.00              | 208,900.00           |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар  | 505,500.00              | 469,155.00              | 36,345.00            |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 275,000.00              | 33,000.00               | 242,000.00           |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 4,250,000.00            | 3,429,000.00            | 821,000.00           |
| 210807        | Газрын төлбөр   | 2,000,000.00            | 475,762.00              | 1,524,238.00         |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>57,425,000.00</b>    | <b>43,938,840.00</b>    | <b>13,486,160.00</b> |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал   | 50,300,000.00           | 36,938,840.00           | 13,361,160.00        |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 7,125,000.00            | 7,000,000.00            | 125,000.00           |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>28,218,000.00</b>    | <b>26,717,065.30</b>    | <b>1,500,934.70</b>  |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>28,218,000.00</b>    | <b>26,717,065.30</b>    | <b>1,500,934.70</b>  |
| 213208        | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,718,000.00           | 26,717,065.30           | 934.7                |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 1,500,000.00            |                         | 1,500,000.00         |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>1,037,374,200.00</b> | <b>1,029,706,500.00</b> | <b>7,667,700.00</b>  |
| <b>132</b>    | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>   | <b>1,037,374,200.00</b> | <b>1,027,886,500.00</b> | <b>9,487,700.00</b>  |
| 132001        | Орон нутгийн төсвөөс  | 1,037,374,200.00        | 1,027,886,500.00        | 9,487,700.00         |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>  |                         | <b>1,820,000.00</b>     | <b>-1,820,000.00</b> |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   |                         | 1,820,000.00            | -1,820,000.00        |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                               | <b>00.00</b>            | <b>00.00</b>            | <b>00.00</b>         |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                              | <b>00.00</b>            | <b>00.00</b>            | <b>00.00</b>         |
| <b>2</b>      | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>   | <b>1</b>                | <b>1</b>                |                      |
| 3             | Төсвийн байгууллага   | 1                       | 1                       |                      |
| <b>5</b>      | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>  | <b>26</b>               | <b>26</b>               |                      |
| 6             | Удирдах ажилтан   | 6                       | 6                       |                      |
| 7             | Гүйцэтгэх ажилтан   | 9                       | 9                       |                      |
| 8             | Үйлчлэх ажилтан   | 6                       | 6                       |                      |
| 9             | Гэрээт ажилтан  | 5                       | 5                       |                      |
| 25            | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)  | 9                       | 9                       |                      |
| 33            | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)  | 6                       | 6                       |                      |

|    |                             |   |   |
|----|-----------------------------|---|---|
| 34 | Гэрээт ажилтан              | 5 | 5 |
| 35 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6 | 6 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д         | Үзүүлэлт   | Гүйцэтгэл           |
|-------------|--|---------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                     |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>7,893,103.06</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>7,893,103.06</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>7,893,103.06</b> |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>78,890.00</b>    |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 78,890.00           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>7,477,040.00</b> |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 7,477,040.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>259,653.06</b>   |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 259,653.06          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>77,520.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 77,520.00           |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>8,617,240.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>8,617,240.00</b> |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 6,617,240.00        |
| 4           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |                     |
| 5           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |                     |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Увс аймгийн Ховд сумын Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Ховд сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ;
- худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлсөн байна.

Ховд сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "CTSYSTEM 6.0.5" программ ашиглан бэлтгэж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагынхаа үйл ажиллагааны онцлог, салбарын стандарт болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Ховд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136,660.0 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл      | /мянган төгрөгөөр/  |                     |
|--|---------------------|---------------------|---------------------|
|  |                     | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт            |
| Б  | 1                   | 2                   | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                               | 0.0                 | 0.0                 | 0.0                 |
| Авлага                                       | 0.0                 | 0.0                 | 0.0                 |
| Бараа материал                               | 271,116.88          | 172,241.11          | (98,875.77)         |
| Үндсэн хөрөнгө                               | 2,190,635.04        | 2,152,850.82        | (37,784.22)         |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>2,461,751.92</b> | <b>2,325,091.93</b> | <b>(136,659.99)</b> |
| Өр төлбөр                                    | 1,952.00            | 8,640.45            | 6,688.45            |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 2,459,799.92        | 2,316,451.48        | (143,348.43)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>2,461,751.92</b> | <b>2,325,091.93</b> | <b>(136,659.99)</b> |

Мөнгөн хөрөнгийн данс тайлант оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 172,241.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 98,875.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,152,850.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,784.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хөрөнгө акталсан нь гол нөлөө үзүүлжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 8,640.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,688.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны төсвийн таналттай холбоотойгоор хүн амын орлогын албан татвар, байгууллагад төлөх бусад өглөгүүд үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,316,451.5 мянган төгрөг болж, 143,348.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 986,952.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөг, нийт 988,952.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 90,217.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,079,169.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,079,169.8 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,027,886.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,820.0 мянган төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 1,006,066.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,006,066.4 мянган төгрөг буюу 97.0 хувийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ                         | Төлөвлөгөө | Гүйцэтгэл  | Зөрүү    | Биелэлт |
|-----|---|------------|------------|----------|---------|
| 1   | Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/         | 655,019.30 | 645,424.80 | 9,594.50 | 98.54%  |
| 2   | Баг, хорооны Үйл ажиллагааны зардал /80106/   | 171,658.40 | 168,933.60 | 2,724.80 | 98.41%  |
| 3   | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/ | 52,033.70  | 50,890.90  | 1,142.80 | 97.80%  |
| 4   | Нийтлэг үйлчилгээ /80112/                     | 79,494.80  | 76,511.20  | 2,983.60 | 96.25%  |
| 5   | Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/          | 28,218.00  | 26,717.10  | 1,500.90 | 94.68%  |
| 6   | Орон нутгийн нөөц хөрөнгө /81102/             | 12,000.00  | 7,042.50   | 4,957.50 | 58.69%  |
| 7   | Мал тооллого /81507/                          | 600.00     | -          | 600.00   | 0.00%   |
| 8   | Хур хог хаягдал орчны бохирдол /82212/        | 650.00     | 650.00     | 0.00     | 100.00% |
| 9   | Улсын баяр наадам /82801/                     | 5,000.00   | 4,837.40   | 162.60   | 96.75%  |

|    |  |           |           |          |        |
|----|--|-----------|-----------|----------|--------|
| 10 | Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх /81701/ | 30,100.00 | 22,658.90 | 7,441.10 | 75.28% |
| 11 | Ахмадын сан /81549/                            | 2,600.00  | 2,400.00  | 200.00   | 92.31% |

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Үзүүлэлт  | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар  |
|-----|---|------------|-----------|--|
| 1   | Программ хангамжийн бүртгэл                           | 3,000.0    | 3,000.0   | Тайлант онд CTSYSTEM 6.0.5 программыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.                              |
| 2   | Унаа, хоолны зарцуулалт                               | -          | -         | Зардал гараагүй  |
| 3   | Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал            | -          | -         | Зардал гараагүй  |
| 4   | Гадаад томилолт, арга хэмжээ                          | -          | -         | Зардал гараагүй  |
| 5   | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | -          | -         | Зардал гараагүй  |
| 6   | Орон тоо  | 742,316.3  | 740,373.9 | Ховд сумын ЗДТГ нь тайлант онд 21 үндсэн албан хаагч, 5 гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна. |
| 6   | Хэвлэл мэдээлэл                                       | -          | -         | Зардал гараагүй  |

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ховд сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 6,617.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 2,000.0 мянган төгрөгийн орлого бүрдсэн бөгөөд 7,893.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ховд сумын Засаг даргын Тамгын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ховд сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 онд 15,164.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,000.0 мянган төгрөгөөр программ хангамж шууд худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт Ховд сумын Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,171,862.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,718.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,374.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,329,989.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,299.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 10,639.9 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд сумын Засаг даргын Тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолоор төрийн байгууллагын тээврийн хэрэгсэлтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан заасан байна. Ховд сумын Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд 379,772.1 мянган төгрөгийн 7 автотээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 3 автотээврийн хэрэгсэл тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна. Үүнээс 1 автотээврийн хэрэгслийг актлах санал хүргүүлсэн, 2 автотээврийн хэрэгслийн бичиг баримтын зөрчилтэй гэх шалтгаанаар тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй байна. Иймд төсвийн захирагчийн зүгээс хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэхийг зөвлөлөө.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ховд сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 163, хугацаа хоцроосон 6, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно. Харин бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.2.1 дэх заалтад “Эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2 дахь заалтад “Бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь заалтад “Соёлын үйлчилгээ”, 25.2.4 дэх заалтад “Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх” гэж заасныг зөрчин аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойн хандивын 36,800.0 мянган төгрөгийн хандивыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Ховд сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,075,358.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 330.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,074,299.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 729.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгчээ. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн бөгөөд Ховд сумын Засаг даргын Тамгын газрын даргын 55 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн.

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                    | Биелэлт  |                    |               |
|-----------------|------------------------|--------------------|----------|--------------------|---------------|
|                 | Тоо                    | Дүн                | Тоо      | Дүн                | Хувь          |
| Төлбөрийн акт   | 1                      | 330.0              | 1        | 220.0*             | 100.0%        |
| Албан шаардлага | 1                      | 1,074,299.0        | 1        | 1,074,299.0        | 100.0%        |
| Зөвлөмж         | 1                      | 729.6              | 1        | 729.6              | 100.0%        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>1,075,358.6</b> | <b>1</b> | <b>1,075,248.6</b> | <b>100.0%</b> |

\*3 багийн гэрээт сахиулд тус бүр 110.0 мянга, нийт 330.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон бөгөөд тайлант онд 1 гэрээт сахиул тэтгэвэрт гарсан тул илүү олгосон цалинг суутган авах боломжгүй нөхцөл үүссэн учраас 2 багийн сахиулаас илүү олгосон суутган авсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Ховд сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.2 дахь заалтад “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны онцлог, салбарын стандартууд болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдсөн эсэхийг анхаарах;

2. Ховд сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг 1 албан хаагчид нийт 6,559.1 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно”, 57.2 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн цалин хөлс нь”, 57.2.2 дахь заалтад “захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс” гэж заасантай нийцэхгүй байгаа тул харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх шаардлагатай;

3. Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/16 дугаар захирамжаар Ховд сумын Засаг даргын Тамгын газрыг 17 орон тоотойгоор баталсан байна. Ховд сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 тушаалаар Ховд сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 5 гэрээт ажилтнаар нэмэгдүүлэн баталсан байна. Тоймлон дурдвал, слесарь болон 1 сахиулыг төрийн үйлчилгээний албан тушаалын цалин хөлсөөр, 3 багийн сахиулыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан нийт 63,663.8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна. Дараагийн аудитаар бүтэц, орон тоог нягтлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39,210.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойд зориулан өгсөн 39,210.0 мянган төгрөгийн хандивыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 25.2.1 дэх заалтад “Эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2 дахь заалтад “Бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь заалтад “Соёлын үйлчилгээ”, 25.2.4 дэх заалтад “Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх”, 25.7 дахь хэсэгт “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |                |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|----------------|-----|---------|-----|
|                   |            |     |                                   |     |                          |     | Залруулсан |     | Залруулаа -гүй |     |         |     |
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо            | Дүн | Тоо     | Дүн |
| Байхгүй           |            |     |                                   |     |                          |     |            |     |                |     |         |     |
| Дүн               |            |     |                                   |     |                          |     |            |     |                |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал |     |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|--|-----|
|                    |             |     |               |     |                 |     |         |     | Тоо                                  | Дүн | Тоо  | Дүн |
|                    | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо  | Дүн |
| Байхгүй            |             |     |               |     |                 |     |         |     |                                      |     |  |     |
| Дүн                |             |     |               |     |                 |     |         |     |                                      |     |  |     |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч<br>утга   | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |     |          |                 |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|
|   |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                 |
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн             |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил  |             |                 |               |     |                 |     |          |                 |
| Байхгүй   |             |                 |               |     |                 |     |          |                 |
| Дүн   |             |                 |               |     |                 |     |          |                 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил  |             |                 |               |     |                 |     |          |                 |
| Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойн хандивын 39,210.0 мянган төгрөгийн хандивыг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан байна. | 1           | 39,210.0        |               |     |                 |     | 1        | 39,210.0        |
| <b>Нийт дүн</b>   | <b>1</b>    | <b>39,210.0</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>39,210.0</b> |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АРИУНСАЙХАН/

2026.02.24